

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ

2025 оны 02 сарын 13-ны өдөр

Дугаар БА-050/2025

Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын нийслэлийн Хан-Уул дүүргийн 20 дугаар хороонд баригдсан өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой 11 давхар, 25.2м*34.0м хүчин чадал бүхий үйлчилгээ, албан конторын зориулалттай барилга байгууламжид Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 07 сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дугаар захирамжийн шийдвэрээр байгуулагдсан 15 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1 Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний 2024/06/21 огноо, 0000037 дугаар, БАЗГ2023/005;

2.2 Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар МК-18/21;

2.3 Захиалагч: Монгол Улсын иргэн Тайж овогтой Санжав эцгийн нэр, Дашжаргал нэр, ЧР51050461 регистрийн дугаар,
Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, 11-р хороолол, 1 байр, 223 тоот, 99112492 холбоо барих утас;

2.4 Барилгын ажлын гүйцэтгэгч: Удам констракшн ХХК оноосон нэр, 9011582113 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6446175 регистрийн дугаар, БУ11-182/24 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар,
Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 1 дүгээр хороо, 19-р хороолол, 42-25 тоот, 99909879 холбоо барих утас;

2.5 Барилга байгууламжийн Туслан гүйцэтгэгч байгууллага: Байхгүй;

2.6 Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: Марс констракшн ХХК оноосон нэр, 9011165043 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, ЗТ16-668/21 зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар;
Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Жуулчны гудамж-42, Сити тауэр, 1104 тоот, 99099985 холбоо барих утас;

2.7 Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: Голдкомпас ХХК оноосон нэр, 9011025043 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5017971 регистрийн дугаар,

Байгууллага: Голдкомпас ХХК
Барилаа байгууламжийг ашиглалтад оруулах комисс

Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 21 дүгээр хороо, Шүрт хотхон 806-1, 88068258 холбоо барих утас;

2.8 Барилга байгууламжийн төлөв байдал: Шаардлага хангасан;

Гурав. Дүгнэлтийн хэсэг

✓ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

□ Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул

- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1 Өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой 11 давхар, 25.2м*34.0м хүчин чадал бүхий үйлчилгээ, албан конторын зориулалттай барилга байгууламж түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэ барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2 Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад ... хоногийн дотор багтаан шилжүүлэх;

б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

3.3 Ашиглагч байгууллагад:

а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;

б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;

в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ
ТАВАР
Барилга байгууламжийг аши
оруулах комисс

3.4 Комиссын акт 3 хуудас, хуралдааны тэмдэглэл 6 хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт 30 хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох ... хуудас материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1 Өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой 11 давхар, 25.2м*34.0м хүчин чадал бүхий үйлчилгээ, албан конторын зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

Хан-Уул дүүргийн 20 дугаар хороо, иргэн С.Дашжаргалын захиалгатай зорьтой 11 давхар, 25.2м*34.0м хүчин чадал бүхий үйлчилгээ, албан конторын зориулалттай барилга

Комиссын дарга:
Нийслэлийн Хяналт шалгалтын газрын
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч



(А.Мөнгөн)

Нарийн бичгийн дарга:
Иргэн С.Дашжаргал

(С.Дашжаргал)

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.



ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 20 ДУГААР ХОРОО, ИРГЭН С.ДАШЖАРГАЛЫН
ЗАХИАЛГАТАЙ ЗООРЬТОЙ 11 ДАВХАР, 25,2м*34,0м ХҮЧИН ЧАДАЛТАЙ
ҮЙЛЧИЛГЭЭ, АЛБАН КОНТОРЫН ЗОРИУЛАЛТТАЙ
БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ
КОМИССЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

Хан-Уул дүүргийн 20 дугаар хороонд баригдсан иргэн С.Дашжаргалын захиалгатай зорьтой 11 давхар, 25.2м*34.0м хүчин чадалтай үйлчилгээ, албан конторын зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын хуралдаан тус барилгын 2 дугаар давхарын танхимд 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр 11:00 цагт 15 гишүүний бүрэлдэхүүнтэй эхэлж, 13:00 цагт дуусав.

Хуралд:

- | | |
|--|---------------|
| 1 Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч | А.Мөнгөн |
| 2 Комиссын нарийн бичгийн дарга: Иргэн С.Дашжаргалын итгэмжлэгдсэн төлөөлөгч | Д.Мөнхбат |
| 3 Нийслэлийн Хяналт шалгалтын газрын Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч | Г.Батбаатар |
| 4 Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ Техник хяналтын хэсгийн ахлагч | Ц.Наранцацрал |
| 5 Барилга хөгжлийн төвийн Барилга барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтсийн инженер | Г.Уртнасан |
| 6 Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК, Шинэ хэрэглэгчийн холболтын хэлтсийн ХХХ-ийн дарга | Д.Сүхбат |
| 7 Нийслэлийн Хяналт шалгалтын газрын Дэд бүтцийн стандарт, хяналтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч | З.Очирпүрэв |
| 8 Технологийн удирдлага төлөвлөлтийн газар Чанар хяналтын хэлтсийн мэргэжилтэн | Н.Даваадэгмид |
| 9 Ус сувгийн удирдах газрын Хэрэглэгчид үйлчлэх төвийн менежер | Д.Болормаа |
| 10 Онцгой байдлын ерөнхий газрын Барилгын зураг төслийн хяналтын байцаагч, дэд хурандаа | М.Батсайхан |
| 11 Үндэсний Төв архивын Зураг төслийн баримтын архивын ахлах архивч | Б.Оюунжаргал |
| 12 Голдкомпас ХХК-ийн Ашиглалтын ус хангамж ариутгах татуургын инженер | Н.Батзаяа |
| 13 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага, Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбооны хүртээмжийн үнэлгээний ажилтан | Н.Эрдэнэтөгс |
| 14 Зураг төслийн Марс констракшн ХХК-ийн Архитектор | Н.Эрдэнэцэцэг |
| 15 Гүйцэтгэгч Удам констракшн ХХК-ийн захирал | С.Чинбаяр |

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ГАЗАР

Барилга байгууламжийг ашиглалтанд
оруулах комисс

ИРЦИЙН БАЙДАЛ

- Мэдэгдэл хүлээн авсан – 15
- Хуралд оролцож үүрэг даалгаврын биелэлтээр санал гаргасан – 15

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Хан-Уул дүүргийн 20 дугаар хороонд баригдсан иргэн С.Дашжаргалын захиалгатай зорьтой 11 давхар, 25.2м*34.0м үйлчилгээ, албан конторын зориулалттай барилгын барилгын ажлын гүйцэтгэл ашиглалтад оруулах шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

СОНССОН НЬ:

Комисст ажилласан гишүүд барилга байгууламжийн зураг төсөл, баримт бичиг, барилгын ажлын гүйцэтгэлийг хянаж танилцаад дараах саналуудыг гаргав.

Ашиглалт хариуцах Голдкомпас ХХК-ийн Ашиглалтын ус хангамж ариутгах татуургын инженер **Н.Батзаяа:**

- Комиссын гишүүдийн үүрэг даалгаварын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна.

Барилгын ажлын гүйцэтгэгч Удам констракшн ХХК-ийн захирал **С.Чинбаяр:**

- Комиссын гишүүдийн үүрэг даалгаварын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна.

Зураг төсөл зохиогч Марс констракшн ХХК-ийн Архитектор **Н.Эрдэнэцэцэг :**

- Ариун цэврийн өрөөнүүдийг зураг төслийх дагуу хийж гүйцэтгэх
 - Зоорийн давхрын шалны өнгөлгөө, будгийг хийж гүйцэтгэх.
 - Нийтийн эзэмжлийн талбайн заслалыг хийж гүйцэтгэх
 - Шатны бариул өнгөлгөө хийж гүйцэтгэх
 - Ариун цэврийн өрөөнүүдийн тоноглол, хуваалт , хаалтыг хийж гүйцэтгэх;
- Комиссын гишүүдийн үүрэг даалгаварын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна.

Захиалагч Иргэн С.Дашжаргалын итгэмжлэгдсэн төлөөлөгч **Д.Мөнхбат:**

- Комиссын гишүүдийн үүрэг даалгаварын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага, Монголын тэргэнцэртэй иргэдийн холбооны хүртээмжийн үнэлгээний ажилтан **Н.Эрдэнэтөгс:**

- Гадна явган хүний зам талбайд харааны бэрхшээлтэй хүний хөтөч зам хийх
- 1,2,4,6,8 Давхрын нийтийн АЦӨ-нүүдэд суултуур болон угаалтууруудыг ХБИ-зориулж стандарт тоноглолоор тоноглох;

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Барилга хөгжлийн төвийн Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтсийн инженер **Г.Уртнасан:**



- Барилгын тухай хуулийн 5.7.1-д заасан норм, нормативын сангийн төлбөрийг тооцуулан төлөх
 - Зоорийн давхрын шалны өнгөлгөө тэмдэг тэмдэглэгээ хийх
 - 1-12 давхрын дотор заслын ажил дуусгах
 - Техникийн давхрын шатны хайс стандартын дагуу өндөрлөх
 - 11-р давхрын терасс хашлага хийж гүйцээх
 - Гадна тохижилт, ногоон байгууламж батлагдсан ЕТ дагуу гүйцэтгэх.
 - Бараа материалын тохирлын гэрчилгээ шалгах
 - 11 давхар терасс гаргах шат зургийн дагуу хийх;
- Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Үндэсний Төв архив, Зураг төслийн баримтын архивын ахлах архивч

Б.Оюунжаргал:

- Архивд баримтаа баримт бүрдүүлэн нийтлэг жагсаалтын дагуу бүрэн бүрдэлтэй өгөх
- Хувийн хэргийн жагсаалтын дагуу бүрэн бүрдүүлэх
- Ажлын болон өөрчлөлтийн зургийг зургийн бүрдлийн дагуу эх хувиар өгөх
- Барилга угсралтын ил далд ажлын акт гарын үсгийн бүрдэл хангах /холбоо дохиолол / тэг тэнхлэгийн актыг эхлэн баримтын ажлын дарааллаар эмхлэн цэгцэлж, акт тус бүрээр дотоод товрьёог стандартаар хийж өгөх
- БУ -ийн тэмдэглэл дэвтэр бүрийн бүрэн баталгаажуулж, ажлын нэр бичиж хаяглах
- Барилгад хэрэглэсэн бараа материалын сертификат, л/ш/дун г/гэрчилгээг дотоод товрьёог хийж өгөх;

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Онцгой байдлын ерөнхий газрын Барилгын зураг төслийн хяналтын байцаагч, дэд хурандаа **М.Батсайхан:**

- Шатнуудын өмнөх гонх хаалтыг зураг төслийн дагуу хийх
- Зоорийн давхрын утаа сорох системийг норм дүрэмд нийцүүлэх
- Автомашины зогсоолд хэвтээ, босоо тэмдэг тэмдэглэгээ хийх.
- Утаа сорох, даралттай агаар өгөх системийн автоматжуулалт хийх
- Гал унтраах автомат бороожуулагчийн системийн төгсгөлд даралт хэмжигч/ манометр хийх/ туршаад видео бичлэгээр баримтжуулах.
- БНБД-ийн 30-01-04-ийн 4-р хавсралтын шаардлага хангаж байгаа эсэх тал дээр тайлбар албан бичиг өгөх. Хэмжилт хийлгэх.

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Ус сувгийн удирдах газар, Хэрэглэгчид үйлчлэх төвийн менежер **Д.Болормаа:**

- БУ-ны салбар 300мм хоолой шугам зөвшөөрөх ажлын зураг үзүүлэх.
- Ундны усны нөөцийн саванд ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэн актаар баталгаажуулах
- БУ-ны салбар шугамын хамгаалалтын зурваст байгаа тул хэмжилт хийлгэх УСУГ-р.
- Нөөцийн савны хаших юүлэх шугамын ус зайлуулах трап хийж өгөх.
- Гадна БУ-ны худгийн фото зургаар авч үзүүлэх

- Гадна ЦУ-ны худагт галын гидрант суурилуулах техникийн нөхцөлийн шаардлагын дагуу галын гидрант суурилуулах.
 - Комиссийн гишүүдийн үүрэг даалгаврыг биелүүлж биелэлтийг хангаснаар байнгын ашиглалтад авах хүсэлтэй байна.
- Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн Техник хяналтын хэсгийн ахлагч
Ц.Наранцацрал:

- 0.4кВ Шитний газардуулгын эсэргүүцэл хэмжүүлж протокол авах
 - 0.4кВ кабелийн байршлыг зөвшилцсөн ажлын зураг
 - Лифт, дулааны узель, усны нөөцийн өрөөнүүдийн тоноглолын суурийг газардуулгын хүрээтэй холбож гагнах
 - Дээрх өрөөнүүдэд (ер шит) татагдсан газардуулгын хүрээг зэврэлтээс хамгаалж зориулалтын бэхээр будах
 - Аянгын хүрээг батлагдсан зургийн дагуу татна
 - Ерөнхий щитний өрөө, ерөнхий шит, давхар дундын шитэнд хаягжуулалд хийж анхааруулах плакат хадах
 - Зүүн урд талын щитний өрөөнүүдийн дотор заслыг гүйцээх
 - Хүчит төхөөрөмжийн угсралтыг гүйцэтгэлийн зургаар баталгаажуулах
 - Барилга баригдах үеийн төлбөр тооцоог барагдуулсан баримт
- Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК, Шинэ хэрэглэгчийн холболтын албаны дарга
Д.Сүхбат:

- Гадна дулааны худаг шат хийх
- Ул цутгах
- Ус буулгах дернаж /яам/ хийх
- Дулааны шугамд хүчитгэл тулгуур хийж өгөх
- Халаалтын цогц төхөөрөмжийн хаяг хийх
- Ус хүлээн авах сувагт ршотик хийх
- Зураг хавсаргах

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Нийслэлийн Хяналт шалгалтын газрын Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч

Г.Батбаатар:

- Барилгад хэрэглэсэн бетоны шинжилгээг үе шат бүрээр үзүүлэх
- Зураг төслийн барилга угсралтын явцыг хяналт хийсэн БУАГТэмдэглэн гүйцээж үзүүлэх
- Зураг төслөөр давхар бүрд 00 ийг хийж баталгаажуулж үзүүлэх
- Ногоон байгууламжийг зурагт тусгасны дагуу хийх
- заслын ажлыг бүрэн дуусгах
- зураг төслийг өөрчлөлт оруулсан гүйцэтгэлийн зураг баталгаажуулж үзүүлэх
- Зоорийн давхрын авто зогсоолын засал, шалны будаг хийж тэмдэг тэмдэглэгээ хийж
- Хөгжлийн бэршээлтэй иргэнд зориулсан 00-д тоноглолыг хийж үзүүлэх

- Зоорийн давхрын ус зайлуулах систем хийж үзүүлэх
- Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Нийслэлийн Хяналт шалгалтын газрын Дэд бүтцийн стандарт, хяналтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч **З.Очирпүрэв:**

- Гадна дулааны шугам /219мм/ зургийн дагуу бэхэлгээ хийх,
 - Худаг зургийн дагуу шат, хаалт, дулаалга агаар гаргаж, цэвэрлэгээ хийх
 - Узелийн шугам, тоноглол цэвэрлэгээ, хаягжуулалт бүрэн хийх
 - Хийн ус цэвэрлэгээний ажиллагаа хэвийн болгох
 - Узелийн ус зайлуулах
 - трап таг , ус зайлуулах гоном угсрах
 - Халаалт, хэрэглээний халуун усны ялтсан бойлерын ачаалал зурагт заагдсанаас нэмэгдүүлгэх байгаа нь ашиглалтын хэвийн нөхцөл хангаж талаар авторын дүгнэлт гаргах
 - Давхруудын агаар сэлгэлтийн механик системүүдийн хэвийн ажиллагааг хангуулах
 - Дээвэр дээрх АС-ийн шахтын дотор байгаа үнэр гаргагч малгайвчаас дээш дулаалгатай өндөрлөх
 - Давхруудын ариун цэврийн өрөөнүүдийг бүрэн засварлаж дуусгах /зарим давхарт 00 байхгүй/
 - 1-2-р давхрын дулаан алдагдал хэвийн болгох мөн граш
- Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Технологийн удирдлага төлөвлөлтийн газрын Чанар хяналтын хэлтсийн мэргэжилтэн **Н.Даваадэмид:**

- Холбооны кабель шугамын тавиурыг гүйцээж хийх гүйцээх.
 - Камержуулалтыг зургийн дагуу бүрэн хийж гүйцэтгэх
 - Давхар бүрийн өрөөнүүдийн болон заалны сүлжээний төгсгөлийн төхөөрөмжийг хийж гүйцэтгэх, дуусгах
- Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Нийслэлийн Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч **А.Мөнгөн:**

- Барилгын тухай хуулийн 14.3, 14.6 заалтын дагуу барилгад чанарын баталгааг гаргаж албан бичгээр ирүүлэх
- Захиалагчийн төлөөлөл Д.Мөнхбатын итгэмжлэлийг шинэчилж ирүүлэх
- БНБД 11-04-16 дагуу зохиогч дүгнэлтээ шинэчилж ирүүлэх

Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Хан-Уул дүүргийн 20 дугаар хороонд баригдсан иргэн С.Дашжаргалын захиалгатай зорьтой 11 давхар, 25.2м*34.0м үйлчилгээ, албан конторын зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын гишүүдийн гаргасан үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, биелэлтээр комиссын дүгнэлт үйлдэх, баталгаажуулах, ашиглалтад оруулахаар шийдвэрлэв.

Танилцсан:

Комиссын дарга: Нийслэлийн Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч



А.Мөнгөн

Тэмдэглэл хөтөлсөн:

Комиссын нарийн бичгийн дарга:
Иргэн

С.Дашжаргал

